



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 16 өдөр

Дугаар

A/704

Ховд

Зарим аж ахуйн нэгжүүдийн үйл
ажиллагааг түр зогсоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "л", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.8, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэл Улаанбаатар хотод Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Баруун бүсийн төв зах, Их буян зах, Эвийн хүч худалдааны төв болон бусад худалдаа үйлчилгээний төвүүдэд хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулахаас бусад төрлийн бараа материал худалдан борлуулдаг үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг зогсоох тухай Ховд аймгийн Засаг даргын 2020 оны А/698 дүгээр захирамжийн хэрэгжилтийг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 08.00 цаг хүртэл сунгасугай.

2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэн сурталчилж ажиллахыг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02.3162
D/Zah-A/704-Bo